

**“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 09-р сарын 12-ны өдөр

Дугаар:24/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2024.09.12-ны өдрийн 14.00 цагт эхлэв.

“Хүрд“ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж танилцууллаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаярын танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 127,255.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 9 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 94.1 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д "Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно" гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Э.Тэмүүжин, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат, Г.Алтансүх, С.Мягмарсүрэн, С.Пүрэвжав, Б.Сумьяа нарын 9 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит бус хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тооллогын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Хүрд ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
2. Охин компанийн дүрмийн сан нэмэгдүүлэх тухай

3. Охин компанийн гүйцэтгэх удирдлага томилох тухай
4. Охин компанийн бизнес төлөвлөгөө батлах тухай
5. ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, нөхөн томилох тухай.
6. Компанийн хагас жилийн тайлан, баланстай танилцах
7. Компанийн хуулийн дагуу хэлэлцэх бусад асуудал

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Хурлын дарга Б.Мөнхбат: Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин нь компанийн нийт 135,266 ширхэг хувьцааны 94,564 ширхэг хувьцаа буюу 69,9 хувь эзэмшигчийн хувьд ТУЗ-д хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулж, дээрх асуудлуудыг хэлэлцэж, шийдвэр гаргуулах саналыг оруулсны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал өнөөдөр хуралдаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ /, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Хэлэлцэх асуудлын талаарх материалтай та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 1 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн. Тиймээс 1 гишүүнийг нөхөн сонгохоор гишүүний товч намтрыг тараасан. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин танилцуулна.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин:

1-р асуудал: Хүрд компани 2016 онд тухайн үеийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу "Хүрд Финанс" ХХК байгуулсан боловч тодорхой үйл ажиллагаа явуулалгүй өнөөдрийг хүрчээ. Тухайн үед банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө аваагүй. 2017 оноос Сэлбэ дэд төвийн 27МВт дулааны станц, Сүхбаатар аймгийн Цэвэрлэх байгууламжийн угсралт зэрэг томоохон төслүүдийн барилга угсралтын ажлуудыг гүйцэтгэж байсан тул дээрх охин компанийн үйл ажиллагаанд анхаарал хандуулж чадаагүй.

2024 оны 04-р сараас "Хүрд Финанс" ХХК-ийн үйл ажиллагааг эхлүүлэх шийдвэр гарган Санхүүгийн зохицуулах хороо болон хувь хүн, аж ахуйн нэгжүүдээс хэд хэдэн удаа зөвлөгөө авлаа. Уг үйл ажиллагаа явуулах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуулийн дагуу шийдвэрлүүлэх нь зохимжтой гэж үзсэнийн дагуу өнөөдрийн ээлжит бус хурлаар уг асуудлыг хэлэлцүүлж байна. Хүрд ХК-ийн

дүрэмд банк бус санхүү, зээлийн үйлчилгээ эрхлэх заалт байх байхгүй тул компанийн дүрмийн 3.4.4.4. Банк бус санхүү, зээлийн үйлчилгээ эрхлэх гэсэн заалтыг нэмж оруулах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Толгой компанийн дүрэмд өөрчлөлт оруулаад Хүрд Финанс ХХК-д тусгай зөвшөөрөл авах юм уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Толгой компани “Хүрд Финанс” ХХК-ийн 100% хөрөнгө оруулагч тул Хүрд ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай юм.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Банк бус санхүүгийн байгууллага нь Санхүүгийн Зохицуулах хороо, Монгол банкны хяналттай байгууллага тул бид итгэдэг. Банк бус санхүүгийн байгууллага байгуулж, өөрийн үйл ажиллагаанд ашигтай байдлаар зохицуулж ажиллах хэрэгтэй тул дэмжиж байна.

Хурлын дарга Б.Мөнхбат: Компанийн дүрэмд Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх заалт нэмж оруулах талаар бусад хувьцаа эзэмшигчдийн саналыг сонсьё. Хуралд оролцож байгаа 9 хувьцаа эзэмшигч бүгд дэмжсэн тул 2-р асуудалдаа орьё.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: 2-р асуудал: Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан босго хөрөнгө 2,5 тэрбум төгрөг болно. Иймд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд “Хүрд Финанс” ХХК-ийн дүрмийн санг эхний ээлжинд 2,5 тэрбум төгрөгөөр баталж өгөх саналыг оруулж байна.

Цаашид итгэлцлийн үйл ажиллагаа явуулах боломжтой. “Хүрд Финанс” ХХК-д хөрөнгө нэмэх эсэх асуудлыг дараа дараагийн хурлаар шийдвэрлүүлнэ. Мөн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, үйл ажиллагааны үр өгөөжийг харах хэрэгтэй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Үйл ажиллагаа эрхлэх хөрөнгийн доод хэмжээ 2,5 тэрбум төгрөг байгаа. Үйл ажиллагааны хүрээнд валютын арилжаа багтах уу? Толгой компани дээр санхүүгийн тайлан нэгтгэж гаргаж байх хэрэгтэй. Аудитлагдсан санхүүгийн тайлангаа танилцуулж байгаарай.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: “Хүрд Финанс” ХХК-ийн тайланг тусад нь гаргаж, бие даасан үйл ажиллагаа эрхэлнэ. Компанийн тухай хуульд заасны дагуу хараат болон охин компанийн санхүүгийн тайлан толгой компанийн тайланд тусгагдана. Валют болон мөнгөн гуйвуулга арилжаа эрхлэх бодолгүй байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: “Хүрд Финанс” ХХК-ийн тайланг тусад нь гаргасан ч компанийн нэгдсэн тайлан гаргаж танилцуулж байх.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: “Хүрд Финанс” ХХК-ийн дүрмийн санг 2,5 тэрбум төгрөгөөр баталж, үйл ажиллагааг эхлүүлэх саналыг дэмжиж байна.

Хурлын дарга Б.Мөнхбат: “Хүрд Финанс ” ХХК-ийн дүрмийн санг 2,5 тэрбум төгрөгөөр батлах санал дээр хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр санал байхгүй тул 3-р асуудалдаа орьё.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: 3-р асуудал: “Хүрд Финанс” ХХК анх байгуулагдахад гүйцэтгэх захирал нь Э.Тэмүүжин миний бие томилогдож байсан.

Өнөөдрийн хуралд “Хүрд Финанс” ХХК-ийн гүйцэтгэх захиралд Гэнэнгийн Цэцгээг танилцуулж байна.

Г.Цэцгээ нь Увс аймгийн Хаан банкинд 1992 оноос нягтлан бодогч, Зээл тооцооны төвийн салбарын эрхлэгч зэрэг албыг 30 гаруй жил тасралтгүй эрхэлж байсан. Улаанбаатар хотод 2024 онд шилжиж ирсэн. Улаангом хотын ХААН банк нь захын хажууд байрладаг, зээлийн үйл ажиллагаа тасралтгүй явуулдаг байсан салбарыг удирдаж ажиллаж байсан банк, санхүүгийн салбарын туршлагатай хүн юм.

Барилгын материалын худалдаа эрхлэлж байгаа Масо Экспо ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Энхжаргалын Ундрахыг томилох санал оруулж байна.

“Хүрд Финанс” ХХК-ийн гүйцэтгэх захирал 25 сая хүртэлх төгрөгийн зээлийг дотоод зээлийн хороогоор баталгаажуулан олгоно. Зээлийн хороо 3 хүний бүрэлдэхүүнтэй байна. 25 саяас дээш төгрөгийн зээлийг Хүрд ХК-ийн гүйцэтгэх захирал эсвэл түүний итгэмжлэгдсэн төлөөлөл оролцуулан батлана гэсэн гүйцэтгэх захирлын эрх хэмжээг энэ хурлаар тодотгож өгч байна.

“Хүрд Финанс” ХХК-ийн үйл ажиллагаанд компанийн ерөнхий нягтлан бодогч хяналт тавьж ажиллана.

Хурлын дарга Б.Мөнхбат: “Хүрд Финанс” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Г.Цэцгээ, Масо Экспо ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Энхжаргалын Ундрахыг томилох саналыг дэмжиж байгаа гишүүд гараа өргөнө үү? Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өөр санал байхгүй 4-р асуудалдаа орьё.

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: 4-р асуудал: “Хүрд Финанс” ХХК-ийн санхүүгийн төлөвлөгөөг танилцуулья. “Хүрд Финанс” ХХК нь банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх ашгийн төлөө хуулийн этгээд байна. Нийт 4 ажилтантай. Гүйцэтгэх захирал Г.Цэцгээ, нягтлан бодогч О.Шинэхүү, 1 эдийн засагч, компаниас хариуцсан ажилтан-1. Хувь нийлүүлсэн хөрөнгө 2,5 тэрбум төгрөг.

Эрхэм зорилго: Үндэсний болон олон улсын санхүүгийн зах зээлд өрсөлдөхүйц, үр ашигт санхүүгийн үйл ажиллагааг цогцлоож, хувь нийлүүлэгч, оролцогч талууддаа үнэ цэнийг бий болгон Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна. Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхдээ Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бүх банк, санхүүгийн байгууллагуудтай шударгаар өрсөлдөж, харилцагч хувь хүн, аж ахуйн нэгжүүдтэй ёс зүйтэй харилцана.

Монгол улсын 21 аймаг, 9 дүүрэгт 2024 оны 1-р улирлын байдлаар 33,850 хувьцаа эзэмшигчдийн 531 ББСБ, 463 салбар нэгж, 11 төлөөлөгчийн газар 5385 ажилтантайгаар давхардсан тоогоор 4,5 сая харилцагч, 1,8 сая зээлдэгчид хүрч үйлчилж байна.

ББСБ нь санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах хууль тогтоомж, олон улсын болон дотоодын стандарт, журмыг баримтлах, дагаж мөрдөх шаардлагатай болно. Үүнд:

Монгол улсын хууль:

1. Компанийн тухай хууль
2. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
3. Нягтлан болох бүртгэлийн тухай хууль
4. Тусгай зөвшөөрлийн тухай хууль
5. Иргэний хууль
6. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
7. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль
8. Татварын ерөнхий хууль
9. Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хууль
10. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
11. Гаалийн албан татварын тухай хууль
12. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
13. Нийгмийн даатгалын тухай хууль
14. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
15. Зээлийн мэдээллийн тухай хууль
16. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
17. Үйл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хууль
18. Хөдөлмөрийн тухай хууль
19. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
20. Мэдээлийн аюулгүй байдлын тухай хууль
21. Кибер аюулгүй байдлын тухай хууль
22. Эрүүгийн хууль
23. Зөрчлийн тухай хууль

Олон улсын болон дотоодын стандарт:

1. Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/
2. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/
3. Мэдээллийн технологийн стандарт MNS;ISO/270001

Батлагдсан журам:

1. Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам
2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ААНБ мөрдөх НББ журам
3. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам
4. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд сууриулсан хяналт шалгалт хийх журам
5. Монгол банкны зээлийн мэдээллийн сангийн журам
6. Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах хаалттай өрийн бичгийг бүртгэх, түүнд хяналт тавих журам
7. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам

Бусад баримт бичиг:

1. “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харилцаа тогтоох тухай” зохицуулалт
2. “Банк бус санхүүгийн байгууллагад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар
3. Монгол улсын ногоон таксономи эдгээр болно.

Банк бус санхүүгийн байгууллагын давуу тал ба сул тал, боломж, эрсдэлийн талаар бичсэнийг та бүхэн харж байна.

Банк бус санхүүгийн байгууллагаас гаргаж буй бүтээгдэхүүн тус бүрийн үнэ өртгийг салбарын дундаж түвшинд барина.

Зээлийн хүү: 2,5-3,5%

Шимтгэл: 0,5-1, %

Хугацаа: 24-60 хүртэл сар

Барьцаа: Хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, үйл ажиллагааны орлого

Зориулалт: Хэрэглээний зээл, Автомашины зээл, Бизнесийн зээл

“Банк бус санхүүгийн байгууллагын ажилтнуудын цалинг хүснэгтээр харуулж байна. Цалингийн сан сард 8,0 сая төгрөг байхаар төлөвлөсөн.

Орлогын төсөөллийг та бүхэн харж байна.

Банк бус санхүүгийн байгууллага ажиллуулснаар 2024 онд 569.2 сая төгрөг, 2025 онд 885.1 сая төгрөг, 2026 онд 1,111.3 сая төгрөг, 2026 онд 1,070.7 сая төгрөг, 2027 онд 1,327.5 сая төгрөгийн орлого олох боломжтой гэсэн төсөөллийг гаргаснаа танилцуулж байна.

Үйл ажиллагааг 10-р сарын 15 гэхэд эхлэх бодолтой байна. Миний зүгээс дотоод үйл ажиллагаанд оролцохгүй. Цаашид хөдөө орон нутагт салбар нээх бодолтой байгаа.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн: Энэ орлогын төсөөлөл бодит төсөөлөл үү, эерэг төсөөлөл үү? Хэдэн төгрөгийн хөрөнгө дээр хийсэн тооцоо вэ? Хөрөнгө оруулалтаа хэдэн жилд нөхөх боломжтой вэ?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Энэ бодит төсөөлөл. Хувь нийлүүлсэн 2,5 тэрбум төгрөг дээр хийсэн тооцоо. Хувь нийлүүлсэн хөрөнгийг энэ тооцооноос харахад 3 жилд төлөх боломжтой гэсэн тооцоо гарч байна. Хөрөнгийн хэмжээг нэмбэл энэ хугацаа багасах боломжтой.

Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх: Банк бус санхүүгийн байгууллага ажиллуулаач гэж олон жилийн өмнө саналаа хэлж байсан. Үйл ажиллагаа эхлэх болсонд баяр хүргэе. Дэмжиж байна. Ажилд нь амжилт хүсье.

Хурлын дарга Б.Мөнхбат: Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн төлөвлөгөөний талаар асуух асуулт байна уу? Дэмжиж байгаа хувьцаа эзэмшигч нар гараа өргөнө үү? Хувьцаа эзэмшигчдийн зүгээс дэмжиж байгаа тул дараагийн асуудалд орьё.

5-р асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Оюунтогтох эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн.

ТУЗ-ийн хараат бус гишүүний нөхөн сонгуульд Тогтох овогтой Идэрцагааныг нэр дэвшүүлж байна. Т.Идэрцагаан нь 1973 онд төрсөн. 1996 онд Политехникийн коллежийг цахилгааны инженер мэргэжлээр төгссөн. 2015 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын магистр төгссөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг. Одоо Чингэлтэй дүүргийн ИТХ-ын ажлын албаны даргаар ажиллаж байгаа. Т.Идэрцагааны талаар асууж тодруулах зүйл байна уу?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Т.Идэрцагаан нэр дэвшигчээс асуух асуулт байна. Таньд Хүрд ХК-тай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компанид хувь эзэмшил, ашиг сонирхол байгаа юу? Хүрд ХК-д таны хамаарал бүхий албан тушаалтан байгаа юу?

Т.Идэрцагаан: Хүрд ХК-тай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид хамаарал байхгүй ээ. Манай эхнэр рестораны үйл ажиллагаа явуулдаг. Хүрд ХК-д хамаарал бүхий албан тушаалтан байхгүй.

Хурлын дарга Б.Мөнхбат: ТУЗ-ийн гишүүнд сонгох асуудлаар дэмжиж байгаа хувьцаа эзэмшигч нар гараа өргөнө үү? Өөр саналтай хувьцаа эзэмшигч байхгүй тул Т.Идэрцагааныг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгов. Сүүлийн асуудалдаа орьё. Компанийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайланг танилцуулна уу?

Ерөнхий нягтлан бодогч, хувьцаа эзэмшигч Б.Сумьяа: Компанийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлан та бүхний өмнө хэвлэмлээр байгаа. Тайлангаас харахад эхний хагас жилийн үндсэн үйл ажиллагааны борлуулалт 2.46 тэрбум төгрөг, ашиг 110.8 сая байхад хүүгийн орлого 1.55 тэрбум төгрөг, нийт ашиг 1.36 тэрбум төгрөг харагдаж байна. Хагас жилийн тайлангийн ашиг нь хүүгийн орлого байгаа нь харагдаж байна. Тайлангаас тодруулж асуух зүйл байна уу?

Хурлын дарга Б.Мөнхбат: Компанийн 2024 оны хагас жилийн санхүүгийн тайлангаас асууж тодруулах зүйл байхгүй бол батлах хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү? Компанийн хуулийн дагуу хэлэлцэх бусад асуудалд ямар асуудал байна?

Гүйцэтгэх захирал Э.Тэмүүжин: Компанийн хуулийн дагуу хэлэлцэх бусад асуудалд хэлэлцэх асуудал байхгүй.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул саналын хуудасны дагуу санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Хүрд ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, Банк бус санхүүгийн байгууллага, зээл, итгэлцлийн үйлчилгээ эрхлэхийг хэлэлцэж батлах асуудлаар.

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

- Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
2. “Хүрд Финанс ” ХХК -охин компанийн дүрмийн санг 2,5 тэрбум төгрөгөөр хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
3. “Хүрд Финанс” ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар Г.Цэцгээ, барилгын материалын худалдаа эрхлэх “Масо Экспо” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Э.Ундрах нарыг батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
4. “Хүрд Финанс” ХХК -охин компанийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Оюунтогтохыг чөлөөлж, хараат бус гишүүнээр Т.Идэрцагааныг сонгох асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
6. Компанийн 2024 оны хагас жилийн тайлан, балансыг хэлэлцэж батлах асуудлаар:
Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 127,255.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.
Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%
Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%


ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2024 оны ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Хүрд ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, Банк бус санхүүгийн байгууллага, зээл, итгэлцэлийн үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрч батлав.
2. “Хүрд Финанс” ХХК -охин компанийн дүрмийн санг 2,5 тэрбум төгрөгөөр хэлэлцэж батлав.
3. “Хүрд Финанс” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Г.Цэцгээ, барилгын материалын худалдаа эрхлэх “Масо Экспо” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Э.Ундрах нарыг томилж батлав.
4. “Хүрд Финанс” ХХК -охин компанийн бизнес төлөвлөгөөг хэлэлцэж батлав.
5. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Л.Оюунтогтохыг чөлөөлж, хараат бус гишүүнээр Т.Идэрцагааныг сонгов.
6. Компанийн 2024 оны хагас жилийн тайлан, балансыг хэлэлцэж батлав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 15.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА  Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

 Г.ГАНТУЯА